



МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

Мэдээ-2

2014 он

МУИС-ийн оюутны дотуур байрыг товч танилцуулах нь

МУИС нь гадаад оюутны 1 байр, дотоод оюутны 5 байртай. 2014-2015 оны хичээлийн жилд 431 өрөөнд 1724 оюутан хүлээн авахаар бэлтгэл ажлаа ханган оюутнуудаа байрлуулаад байна.

2014-2015 оны хичээлийн жилд МУИС-ийн **оюутны дотуур байр илүү хүртээмжтэй, ая тохитой боллоо.**

- Өнгөрсөн хичээлийн жилийн мөн үетэй харьцуулахад оюутан оршин суух өрөөний тоог нэмэгдүүллээ. Сургуулийн захиргааны зүгээс оюутны байранд аль болох олон оюутан байрлуулахын тулд офиссын зориулалттай зарим өрөөг чөлөөлөх замаар 17 өрөөнд 68 оюутан нэмж байрлуулсаа. Түүнчлэн МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрийн оюутнуудад тодорхой тооны дотуур байрны квот олгодог боллоо.
- Дотуур байранд орох хүсэлт гаргасан бүх оюутнууд хамрагдсан.
- Засварын ажил: МУИС-ийн Оюутны 2 ба 3-р байрны цонх солих засварын ажил, Оюутны 1-р байрны фасад, дээврийн засварын ажил, Оюутны 3 ба 5-р байрны хар цаасан дээвэр, фасад, гадна хашааны засварын ажил, Оюутны 1,2,3,4-р байрны ялтсан бойлер солих засварын ажлыг хийж гүйцэтгэжээ. Түүнчлэн оюутны байрны гал тогооны өрөөнд цахилгаан зуух байрлуулснаар өрөөндөө хоол үнд бэлтгэх явдал хязгаарлагдаж, эрүүл ахуй, галын аюулгүй байдал дээшлэх нөхцөл бүрдэв.
- Мөн оюутны байрны уншлагын танхмийг ном сурах бичиг, сэтгүүлээр хангах, эмнэлгийн үйлчилгээг байраар үзүүлэх ажлыг зохион байгуулахаар болж байна.

Дотуур байрыг хэрхэн хуваарилдаг вэ?

МУИС-ийн захирлын 2014 оны 08 дугаар сарын 29-ны өдрийн А/284 тоот тушаалаар “МУИС-ийн Оюутны дотуур байрны журам” батлагдаж, түүний дагуу зохион байгуулалтын ажлыг хэрэгжүүллээ. Шинэчлэгдсэн журмаар Сургуулийн захиргаанаас оюутны хяналтын тоог гаргаж, бүрэлдэхүүний сургуулийн захиргаа, сургалтын алба өргөдлийг шийдвэрлэдэг үйл ажиллагаа хэвээр байгаа бөгөөд харин алба хэлтсийн ажил үүрэгт зарим өөрчлөлт орж, оюутны байрны квотыг нийт хүсэлт гаргасан оюутны тоонд үндэслэн гаргаж, өрөө, тасалгааны хуваарилалтыг ил тод шударга зохион байгуулах ажлыг СНА зохион байгуулж байна.

Шинэ журам гарснаар оюутнуудын хувьд ямар давуу тал байна вэ?

Оюутнуудад дараах давуу талтай байна. Үүнд:

- Оюутны байранд гадны сургуулийн оюутан болон айл амьдрах, өрөө тасалгаа хуваарилалахад тал тохой татах, өрөөний тоог дарагдуулах зэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж бүрдэж байна.
- Дотуур байртай холбоотой захиргааны үйл ажиллагааны процесс хялбар боллоо. Бүрэлдэхүүн сургуулиуд батлагдсан квотын дагуу оюутнуудаа бүртгэн, гэрээ байгуулж, байрлуулна. Оюутнуудаас давхардсан мэдээлэл, бичиг баримт шаардахгүй болсноор чирэгдэл багасна.
- Байрлуулахдаа өрөөг сугалаагаар хуваарилж байгаа нь оюутнуудын хувьд сонголт өгч, шударга бус үйлдэл гарахаас урьдчилан сэргийлнэ.
- Магистр, докторын түвшний оюутнууд байранд амьдрах боломжтой болсон.
- Түүнчлэн МУИС-ийн оюутны байгууллагын төлөөллийг хяналт мониторинг хийх чиг үүрэгтэйгээр оролцуулах болсон нь аливаа зөрчлийг илрүүлэн арилгахад оюутнуудын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Бүрэлдэхүүн сургуулиудын хувьд дотуур байранд амьдрах оюутнуудын тоо

Байрны хуваарилалтын квотыг тогтоохдоо тухайн бүрэлдэхүүн сургуулийн нийт оюутны тоонд хувь тэнцүүлэх замаар шийдвэрлэсэн бөгөөд энэ хичээлийн жилд ХЗС-120, ХШУИС-276, ОУХНУС-68, БС-312, МСҮТ-48, ШУС-900 оюутан байрлуулна.

Дотуур байранд ороход ямар оюутнууд давуу эрхтэй вэ?

Суралцагчийн сурах түвшин, хаяг, ар гэрийн байдлыг үндэслэх бөгөөд дараах дарааллаар эрэмбэлнэ. Үүнд:

1 түвшний суралцагч	хөдөө орон нутгийн, бүтэн өнчин болон ар гэрийн гачигдалтай	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангайд амьдардаг болон бүтэн өнчин
2 түвшний суралцагч	хөдөө орон нутгийн, бүтэн өнчин болон ар гэрийн гачигдалтай	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангайд амьдардаг болон бүтэн өнчин
3 түвшний суралцагч	хөдөө орон нутгийн, бүтэн өнчин болон ар гэрийн гачигдалтай	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангайд амьдардаг болон бүтэн өнчин
4-5 түвшний суралцагч	хөдөө орон нутгийн, бүтэн өнчин болон ар гэрийн гачигдалтай	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангайд амьдардаг болон бүтэн өнчин
Магистр, докторын түвшний суралцагч	хөдөө орон нутгийн	Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг болох Багануур, Багахангайд амьдардаг.


Дотуур байртай холбогдолтой гомдол саналыг хэрхэн шийдвэрлэх вэ?

Оюутан суралцагсад дотуур байртай холбоотой аливаа санал гомдлоо Сургалтын нэгдсэн алба болон бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албаны холбогдох мэргэжилтэн зааварлагч нарт биеэр гаргахын зэрэгцээ дараах хаягаар /емайл/ утсаар ирүүлж болно.

Байр/ Өрөөний №	Албан тушаал	Дотуур 75754400	И-майл
Шинжлэх ухааны сургууль			
2-260	Зааварлагч	2719 6115	sasro@num.edu.mn
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль			
3-230	Зааварлагч	6101 3313	sasero@num.edu.mn
Бизнесийн сургууль			
4-202	Зааварлагч	4133	bsro@num.edu.mn
Хууль зүйн сургууль			
3-206	Зааварлагч	3503	lsro@num.edu.mn
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль			
5-203	Зааварлагч	5103	siaparo@num.edu.mn

Ирсэн гомдол саналыг холбогдох албан тушаалтан судлан шийдвэрлээд эргэн мэдэгдэнэ.

Хичээлийн байр, оюутны байрны байршил



Дотуур байр

№	Байр	Байршил	Холбоо барих
1	Оюутны 1-р байр	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1163
2	Оюутны 2-р байр	УБ, СБД, Бага тойруу, 6-р хороо /Хичээлийн 2-р байрны хойно/	77307730-1164
3	Оюутны 3-р байр	УБ, СБД, 8-р хороо, Оюутны А хотхон	77307730-1165
4	Оюутны 4-р байр /гадаад оюутны байр/	УБ, СБД, 8-р хороо /Дашчойлин хийдийн зүүн талд/	77307730-1166
5	Оюутны 5-р байр	УБ, СБД, 8-р хороо Оюутны А хотхон	77307730-1167
6	Оюутны 6-р байр /худалдааны дотуур/	УБ, СБД, 8-р хороо /спортын төв ордны зүүн талд/	77307730-1168

МУИС-ИЙН СУРГАЛТЫН НЭГДСЭН АЛБА